



МОНГОЛ УЛСЫН  
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙДЫН  
ТУШААЛ

2014 оны 05 сарын 13 өдөр

Дугаар 4/113

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.4 дэх заалт, Батлан хамгаалахын сайдын 2019 оны “Цэргийн мэргэжлийн боловсрол, шаталсан сургалтын тогтолцоо батлах тухай” А/159 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн Батлан хамгаалахын удирдлагын академид элсэгчийг сонгон шалгаруулах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн Батлан хамгаалахын удирдлагын академид элсэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах элсэлтийн комиссыг тушаалааар томилон ажиллуулж байхыг яамны Төрийн нарийн бичгийн дарга бригадын генерал Д.Ганхуягт үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан “Журам шинэчлэн батлах тухай” Батлан хамгаалахын сайдын 2017 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн А/04 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /хурандаа Б.Эрхэмбаяр/-т даалгасугай.



Г.САЙХАНБАЯР

1321100259

Батлан хамгаалахын сайдын 2021 оны  
05 дугаар сарын 23-ны өдрийн  
23 дугаар тушаалын хавсралт

ҮНДЭСНИЙ БАТЛАН ХАМГААЛАХЫН ИХ СУРГУУЛИЙН БАТЛАН  
ХАМГААЛАХЫН УДИРДЛАГЫН АКАДЕМИД ЭЛСЭГЧИЙГ  
СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, Хил хамгаалах ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газар, Дотоодын цэргийн штаб болон үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагын захиалгаар түүнчлэн батлан хамгаалахын гадаад харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд гадаадын орны хүсэлтээр Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн Батлан хамгаалахын удирдлагын академид элсэн суралцах офицер /цаашид “элсэгч” гэх-ыг сонгон шалгаруулахад энэхүү журмыг баримтална.

1.2. Энэхүү журмын зорилго нь үндэсний аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах болон төрийн цэргийн байгууллагад удирдах албан тушаалд ажиллах, мэдлэг, чадвар, дадалтай, зөв хандлага, төлөвшил, ёс суртахуунтай офицерыг сонгон шалгаруулж, Батлан хамгаалахын удирдлагын академид элсүүлэхэд оршино.

1.3. Батлан хамгаалахын удирдлагын академид элсэгчид тавигдах шаардлагыг тодорхойлох, элсэгчийг сонгон шалгаруулах, элсэлтийн шалгалтыг зохион байгуулах, суралцах эрх олгох, сургалтын гэрээ байгуулахтай холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.4. Зэвсэгт хүчний тухай, Төрийн албаны тухай, Цэргийн албаны тухай, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай, Дээд боловсролын тухай хууль, Батлан хамгаалахын сайдын 2019 оны А/159 дүгээр тушаалаар батлагдсан “Цэргийн мэргэжлийн боловсрол, шаталсан сургалтын тогтолцоо”, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 187 дугаар тушаалаар батлагдсан “Магистр, докторын сургалт эрхлэхэд баримтлах нийтлэг журам” болон холбогдох бусад хууль тогтоомж нь энэхүү журмын эрх зүйн үндэслэл болно.

Хоёр. Элсэгчид тавигдах шаардлага

2.1. Элсэгч нь үндэсний болон гадаадын цэргийн их, дээд сургууль төгссөн, цэргийн ухааны бакалаврын зэрэгтэй, албан тушаалын болон мэргэшүүлэх сургалтад хамрагдаж төгссөн, батальон /дивизион/-ы захирагч, захирагчийн орлогч, тусгай салбарын захирагч, түүнтэй адилтгах буюу түүнээс дээш албан тушаалд З-аас доошгүй жил ажиллаж байгаа, 36 хүртэлх насын дунд болон ахлах офицер /ахмадаас дэд хурандаа цолтой/ байна.

2.2. Агаарын цэргийн анги, салбарын нисгэгчийн мэргэжилтэй элсэгч нь 34 хүртэл насын дунд болон ахлах офицер /ахмадаас хошууч цолтой/ байж болно.

2.3. Энэхүү журмын 2.1, 2.2-т заасан элсэгчийн насын дээд хязгаарыг тогтоохдоо тухайн оны хичээлийн жил эхлэх өдрөөр тасалбар болгон тооцно.

2.4. Элсэгчид дараах нийтлэг шаардлага тавигдана:

2.4.1. Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1-т заасан нийтлэг үүрэг, төрийн албан хаагчийн ёс зүйн шаардлагыг хангасан байх;

2.4.2. Үндэсний аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах болон төрийн цэргийн байгууллагад тасралтгүй, үр бүтээлтэй ажиллаж байгаа, анги,

байгууллага, хамт олондоо нэр хүндтэй, зан харьцаа, ёс суртахууны хувьд төлөвшсөн, гэмт хэрэг, сахилгын зөрчил гаргаагүй байх;

2.4.3.хариуцсан салбар, нэгж, алба, тасаг нь сүүлийн 2 жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт болон цогцолбор ба командлалын шалгалтын дүнгээр “В”-ээс доошгүй үнэлгээтэй байх;

2.4.4.төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшин нь сүүлийн 2 жилд “Хангалттай” түүнээс дээш үнэлэгдсэн, офицерын түвшин тогтоох үзлэг, сүүлийн 2 удаагийн сургуулийн жилийн төгсгөлийн шалгалтаар “В” түүнээс дээш дүнтэй шалгагдсан байх;

2.4.5.цэргийн ухааны бакалаврын дипломын голч дүн нь 2.8-аас доошгүй үнэлгээтэй, цэргийн хэргийн зохих мэдлэг, чадвар, дадлыг эзэмшсэн байх;

2.4.6.цэргийн эмнэлгийн комиссын үзлэгээр орж, биеийн эрүүл мэндээр тэнцсэн байх;

2.4.7.өөрийгөө илэрхийлэх, монгол хэлээр бичгийн ажил, дасгал, даалгавар боловсруулах чадвартай байх;

2.4.8.гадаад хэл /орос, англи хэлний аль нэг/, компьютерын дундаас дээш түвшний мэдлэгтэй, хэрэглээний үндсэн программуудыг бүрэн эзэмшсэн байх;

2.4.9.нэгтгэл, анги, байгууллагадаа өмч хөрөнгийн тооцоогүй байх;

2.4.10.энэ журмын 3, 4 дүгээр зүйлд заасан элсэлтийн сонгон шалгаруулалт, элсэлтийн шалгалтад тэнцсэн байх.

2.5. Энэхүү журмын 1.1-т заасан сургалтад суралцах гадаад орны элсэгчид энэхүү журмын 2.1, 2.2, 2.4-т заасан нийтлэг шаардлага хамаарахгүй бөгөөд элсэгч нь цэргийн их, дээд сургууль төгссөн, бакалаврын зэрэгтэй дүйцэх боловсрол эзэмшсэн, ахмадаас хошууч хүртэл цэргийн цолтой офицер байна.

#### Гурав. Элсэлтийн сонгон шалгаруулалт

3.1. Батлан хамгаалах яамны Төрийн захиргааны удирдлагын газар нь Батлан хамгаалахын удирдлагын академид суралцуулах хүний тоо, цэргийн мэргэжлийн чиглэлийн талаарх албан бичгийг Зэвсэгт хүчний Жанжин штаб, Хил хамгаалах ерөнхий газар, Дотоодын цэргийн штаб, Онцгой байдлын ерөнхий газар болон яамны харьяа байгууллагуудад хүргүүлнэ.

3.2. Энэхүү журмын 1.1-т заасан элсэлтийн сонгон шалгаруулалтыг Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар томилогдсон элсэлтийн шалгалтын комисс зохион байгуулна.

3.3. Элсэлтийн шалгалтын комисс сонгон шалгаруулалтыг хичээлийн жил эхлэхээс 2 сарын өмнө зохион байгуулж, Батлан хамгаалахын сайдын тушаалаар батлуулна.

3.4. Элсэлтийн сонгон шалгаруулалтыг дараах байдлаар зохион байгуулна:

3.4.1.Батлан хамгаалах яам элсэлтийн сонгон шалгаруулалт зохион байгуулах зарыг сонгон шалгаруулалтаас 2 сарын өмнө “Соёмбо” сонин болон БХЯ-ны вэбсайт [/http://www.mod.gov.mn/](http://www.mod.gov.mn/), ЗХЖШ-ын вэбсайт [/http://www.gsmaf.gov.mn/](http://www.gsmaf.gov.mn/)-аар нээлттэй зарлана;

3.4.2.Батлан хамгаалахын удирдлагын академид элсэх хүсэлтэй офицер /цаашид “офицер” гэх/ нь сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтээ нэгтгэл, анги, байгууллагын захирагч /дарга/-д бичгээр гаргана;

3.4.3.нэгтгэл, анги, байгууллага нь сонгон шалгаруулалтад оролцох офицерын хүсэлт, сурлагын дүн, ажлын үзүүлэлт, манлайлал, ёс суртахуун, сахилга хариуцлага, эрүүл мэндийн байдал болон энэхүү журмын 2.1, 2.2, 2.4-т заасан шаардлагыг хангасан эсэхийг захирагч /дарга-/ийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэр гаргаж, энэхүү журмын 3.6 3.7-д заасан материалыг бүрдүүлж, сонгон шалгаруулалт зохион байгуулах жилийн 04 дүгээр сарын 25-ны дотор харьяалах байгууллагын мэргэжлийн хэлтэс, газар, командлалд хүргүүлнэ;

3.4.4.мэргэжлийн хэлтэс, газар, командлал нь офицеруудын материалыг хянан хэлэлцээд тухайн жилийн 05 дугаар сарын 05-ны дотор Зэвсэгт хүчний Жанжин штабт хүргүүлнэ;

3.4.5.Зэвсэгт хүчний Жанжин штаб, Хил хамгаалах ерөнхий газар, Дотоодын цэргийн штаб, Онцгой байдлын ерөнхий газар болон яамны харьяа байгууллагууд санал, офицеруудын материалыг тухайн жилийн 05 дугаар сарын 20-ны дотор Батлан хамгаалах яамны Төрийн захиргааны удирдлагын газарт хүргүүлнэ;

3.4.6.Батлан хамгаалах яамны Төрийн захиргааны удирдлагын газар нь энэхүү журмын 3.4.5-д заасан байгууллагаас ирүүлсэн санал, холбогдох материалыг судлан нэгтгэж, элсэлтийн шалгалтын комисст хүлээлгэн өгнө;

3.4.7.элсэлтийн шалгалтын комисс нь сонгон шалгаруулалтад оролцуулахаар ирүүлсэн офицеруудын материалыг хянан хэлэлцээд энэхүү журмын 2.1, 2.2, 2.4-т заасан шаардлагыг хангасан офицеруудын нэрийн жагсаалтыг гаргаж, элсэлтийн шалгалт авахаас 14 хоногийн өмнө Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн даргад танилцуулна;

3.4.8.Батлан хамгаалах яамны Төрийн захиргааны удирдлагын газар офицеруудыг Цэргийн төв эмнэлэгт эрүүл мэндийн үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулна;

3.4.9.цэргийн эмнэлгийн комисс нь Засгийн газрын 2017 оны 144 дүгээр тогтоолоор батлагдсан “Иргэнийг цэргийн жинхэнэ албанд эрүүл мэндээр тэнцүүлэх болон цэргийн алба хаагчийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлох журам”-д заасны дагуу офицерын биеийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлон дүгнэлт гаргаж, холбогдох материалыг элсэлтийн шалгалтын комисст хүргүүлнэ;

3.4.10.элсэлтийн шалгалтын комисс энэхүү журмын 2.1, 2.2, 2.4-т заасан шаардлагыг хангасан, биеийн эрүүл мэндээр тэнцсэн офицерыг элсэлтийн шалгалтад хамруулна.

### 3.5. Офицерыг дараах тохиолдолд сонгон шалгаруулалтад оролцуулахгүй:

3.5.1.баримт бичиг дутуу бүрдүүлсэн;

3.5.2.эрүүл мэндийн үзлэгт бүрэн хамрагдаагүй;

3.5.3.сонгон шалгаруулалтын явцад сахилгын зөрчил гаргасан болон гэмт хэрэг, зөрчилд холбогдсон;

3.5.4.Төрийн албаны тухай хууль, цэргийн сахилгын дүрэмд заасан сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа дуусаагүй;

3.5.5.хүндэтгэх шалтгаангүйгээр сонгон шалгаруулах үйл ажиллагаанд 3-аас дээш удаа хоцорсон.

### 3.6. Офицер нь дараах материалыг бүрдүүлнэ:

3.6.1.сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт бүхий өргөдөл;

3.6.2.төрийн албан хаагчийн анкет /маягт №1/;

3.6.3.иргэний үнэмлэх, офицерын үнэмлэхийн хуулбар /цол, албан тушаалд томилогдсон хуудасны хамт/;

3.6.4.цэргийн мэргэжлийн болон бакалаврын диплом, албан тушаалын болон мэргэшүүлэх сургалтын гэрчилгээний хуулбар, хавсралтын хамт /нотариатаар батлуулсан байх/;

3.6.5.сурлагын дэвтрийн хуулбар /сүүлийн 2 жилд хамрагдсан түвшин тогтоох, цогцолбор, командлалын шалгалтын дүн/;

3.6.6.цээж зураг /4x6 см хэмжээтэй, 3 хувь/;

3.6.7.цагдаагийн байгууллагын тодорхойлолт.

3.7. Нэгтгэл, анги, байгууллага нь офицертой холбоотой дараах материалыг бүрдүүлнэ:

3.7.1.нэгтгэл, анги, байгууллагын захирагч /дарга/-ийн санал /албан бичиг/;

3.7.2.захирагч /дарга/-ийн зөвлөлийн хуралдааны шийдвэр;

3.7.3.ажил байдлын тодорхойлолт;

3.7.4.офицерын төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн үнэлгээний хуулбар /сүүлийн 2 жилээр/;

3.7.5.офицерын хариуцсан салбар, нэгж, алба, тасгийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт болон цогцолбор ба командлалын шалгалтын дүнгийн хуулбар /сүүлийн 2 жилээр/.

#### Дөрөв. Элсэлтийн шалгалт

4.1. Офицерын өрөнхий тактик, хууль эрх зүй, гадаад хэлний мэдлэг, найруулан бичих ур чадвар, бие бялдрын бэлтгэлжилтийн түвшинг тогтоох зорилгоор дараах шалгалтуудыг авна:

4.1.1.биеийн тамирын бэлтгэл;

4.1.2.хууль эрх зүйн мэдлэг;

4.1.3.гадаад хэлний шалгалт;

4.1.4.бичгийн шалгалт;

4.1.5.тактикийн цогцолбор шалгалт.

4.2. Биеийн тамирын бэлтгэлийн шалгалтыг офицерын биеийн жингийн зохистой харьцаа, бие бялдрын бэлтгэлжилтийн түвшинг тогтоох зорилгоор ЗХЖШ-ын даргын 2017 оны А/505 дугаар тушаалаар батлагдсан “Цэргийн биеийн тамирын бэлтгэлийн стандарт”-ын дагуу явуулна. Биеийн тамирын бэлтгэлийн шалгалтад тэнцсэн офицерыг дараагийн шалгалтад оруулна.

4.3. Хууль эрх зүйн мэдлэгийн шалгалтыг офицерын эрх зүйн мэдлэгийн түвшинг тогтоох зорилгоор батлан хамгаалахын хууль тогтоомж, цэргийн нийтлэг дүрмүүд болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд тестийн аргаар зохион байгуулна. Хууль эрх зүйн мэдлэгийн шалгалт нь нийт шалгалтын 15 хувь байна.

4.4. Гадаад хэлний шалгалтыг офицерын гадаад хэлнээс орчуулах, мэдээлэл олзворлох, судалгаа боловсруулалт хийх мэдлэгийн өрөнхий түвшинг тогтоох зорилгоор орос, англи хэлний аль нэгийг сонгож тестийн аргаар зохион байгуулна. Гадаад хэлний шалгалт нь нийт шалгалтын 15 хувь байна.

4.5. Бичгийн шалгалтыг офицерын цэргийн хэргийн мэдлэг, тактикийн сэтгэлгээ, асуудлыг илэрхийлэх, найруулан зөв бичих ур чадварын түвшинг тогтоох зорилгоор эсээ бичих аргаар явуулна. Элсэлтийн шалгалтын комисс эсээ бичих З-аас доошгүй сэдвийг элсэлтийн сонгон шалгаруулалтын зартай хамт урьдчилан мэдээлнэ. Бүх офицерууд элсэлтийн шалгалтын комиссын сонгосон нэг сэдвээр 250-300 үтэй эсээг 1 цагийн хугацаанд гараар бичнэ. Элсэлтийн шалгалтын эхний 3 байрт шалгарсан эсээг “Соёмбо” сонинд нийтэлж болно. Бичгийн шалгалт нь нийт шалгалтын 20 хувь байна.

4.6. Тактикийн цогцолбор шалгалтыг офицерын ерөнхий тактикийн мэдлэг, байлдааныг зохион байгуулж явуулах ур чадварын түвшинг тогтоох зорилгоор явуулах бөгөөд онолын болон дадлагын хэсэгтэй байна. Онолын шалгалтыг нэгтгэл ангийн бүрэлдэхүүнд болон бие даан үүрэг гүйцэтгэх үед батальон /дивизион/-ы байлдааныг бэлтгэж явуулах, төрөл, тусгай мэргэжлийн цэргийн салбаруудыг хэрэглэх, бүх төрлийн хангарт, удирдлагыг зохион байгуулах асуудлын хүрээнд тестиийн аргаар зохион байгуулна. Дадлагын хэсгийг тактикийн шуурхай дасгал боловсруулах замаар гүйцэтгэнэ. Тактикийн цогцолбор шалгалт нь элсэлтийн үндсэн шалгалт байх бөгөөд нийт шалгалтын 50 хувь байна.

4.7. Элсэлтийн шалгалтын комисс шалгалтын материал, хариултыг тухайн шалгалтыг зохион байгуулахаас нэг хоногийн өмнө бэлтгэж, комиссын даргаар батлуулан битгүүмжилж, комиссын даргын сейфт комиссын нарийн бичгийн даргын лацаар лацдаж хадгална.

4.8. Энэхүү журмын 4.1.2, 4.1.3, 4.1.4, 4.1.5-д заасан шалгалтыг тусгай тэмдэг дарсан цаасан дээр гүйцэтгэх ба энэхүү журмын 4.1.5-т заасан тактикийн цогцолбор шалгалтын дадлагын хэсгийг цэргийн байр зүйн зураг дээр боловсруулна.

4.9. Элсэлтийн шалгалтын комисс нь офицер бүрт шифр оноож өгнө. Офицер нь элсэлтийн шалгалтын комиссын зааврын дагуу шифрийг шалгалтын цаас, байр зүйн зураг дээр тэмдэглэх бөгөөд өөрийн цол, овог нэрийг бичихийг хориглоно.

4.10. Элсэлтийн шалгалтын үед офицер бусдаас дэмжлэг авсан, урьдчилан бэлтгэсэн материалыг хуулж ашигласан, бусдад тусалсан, гар утас болон төрөл бүрийн техник хэрэгсэл ашигласан тохиолдолд элсэлтийн шалгалтаас хасна.

4.11. Элсэлтийн шалгалтын комиссын гишүүн бүр элсэлтийн шалгалтын материалыг үнэлж дүн тавих бөгөөд шалгалтын дүнг тухайн офицерт танилцуулж гарын үсэг зуруулна.

4.12. Элсэлтийн шалгалтын комисс шалгалт бүрээр офицеруудыг онооны дарааллаар байр эзлүүлж, жагсаалт гаргана.

4.13. Офицеруудын оноо тэнцсэн тохиолдолд тактикийн цогцолбор шалгалтын дүн, бакалаврын дипломын голч дүн, ажил байдлын тодорхойлолт, цэргийн жинхэнэ алба хаасан хугацаа зэргийг харгалзан элсэлтийн шалгалтын комисс шийдвэрлэнэ.

4.14. Шалгалтын төгсгөлд элсэлтийн шалгалтын комисс бүх шалгалтын дүнг нэгтгэж, зэвсэгт хүчин, хилийн цэрэг, дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллагын офицеруудыг тус бүрт нь онооны дарааллаар байр эзлүүлж, комиссын хурлаар хэлэлцэж, Батлан хамгаалахын сайдын баталсан хяналтын тоонд багтсан офицеруудыг элсүүлэх дүгнэлт гаргана.

4.15. Элсэлтийн шалгалтын комиссын дарга шалгалтад оролцсон нийт офицеруудын шалгалтын оноо, нэгдсэн дүнг шалгалт өгсөн бүрэлдэхүүнд нээлттэй зарлаж, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн даргад танилцуулна.

4.16. Гадаадын орны Зэвсэгт хүчний алба хаагчийг элсэн суралцуулах асуудлыг батлан хамгаалахын гадаад харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга шийдвэрлэнэ.

4.17. Гадаадын орны офицерын суралцах хугацаанд эдлэх хөнгөлөлт, байр, хоол, унаа, тэтгэлэг болон бусад хангалтыг хоёр улсын Батлан хамгаалах яамд хооронд байгуулсан гэрээгээр зохицуулна.

Тав. Элсэгчид суралцах эрх олгох, сургалтын гэрээ байгуулах

5.1. Энэ журмын 4.14-т заасан дүгнэлтийг үндэслэн элсэгчийг Батлан хамгаалахын удирдлагын академид суралцуулах шийдвэрийг Батлан хамгаалахын сайдын тушаалаар баталгаажуулна. Батлан хамгаалахын сайдын тушаал батлагдсанаар элсэгчийн суралцах эрх үүснэ.

5.2. Батлан хамгаалах яамны Төрийн захиргааны удирдлагын газар нь элсэгчийн материалыг холбогдох шийдвэрийн хамт Үндэсний батлан хамгаалахын их сургуульд хүлээлгэн өгнө.

5.3. Үндэсний батлан хамгаалахын их сургууль элсэгчтэй “Суралцах тухай” гэрээг байгуулж Батлан хамгаалах яамны Төрийн захиргааны удирдлагын газрын даргаар батлуулна. Гэрээнд суралцах мэргэжил, хугацаа, гэрээлэгч талуудын эрх, үүрэг, хариуцлагыг нарийвчлан тусгана.

Зургаа. Офицерын болон элсэлтийн шалгалтын комиссын эрх, үүрэг

6.1. Офицер нь дараах эрх, үүрэгтэй:

6.1.1.сонгон шалгаруулалтад орох нөхцөл, бололцоогоор хангуулах;

6.1.2.элсэлтийн шалгалтын материал, дүнтэйгээ газар дээр нь шууд танилцах;

6.1.3.элсэлтийн шалгалт дууссанаас хойш 2 цагийн дотор шалгалттай холбоотой өргөдөл, гомдлоо амаар болон бичгээр гаргаж, шийдвэрлүүлэх;

6.1.4.элсэлтийн шалгалтын комиссын тогтоосон цагт, заасан газарт бэлэн байх.

6.2. Элсэлтийн шалгалтын комисс нь дараах эрх, үүрэгтэй:

6.2.1.сонгон шалгаруулалт, элсэлтийн шалгалтын хугацааг товлох;

6.2.2.шалгалтын материалыг бэлтгэж нууцлалыг хангах;

6.2.3.холбогдох хууль тогтоомжийг чанд мөрдөн сонгон шалгаруулалт, элсэлтийн шалгалтыг шударга, ил тод, нээлттэй явуулах;

6.2.4.шалгалт бүрийн дүнг тухай бүрт нь зарлаж, нэгдсэн дүнг шалгалт дууссан өдөртөө багтаан зарлаж баталгаажуулах.

Долоо. Бусад зүйл

7.1. Сонгон шалгаруулалт, элсэлтийн шалгалттай холбоотой аливаа маргаантай асуудлыг элсэлтийн шалгалтын комисс тухай бүр хянан шийдвэрлэнэ. Элсэлтийн шалгалтын комиссын шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл офицер нь Батлан хамгаалах яамны Төрийн захиргааны удирдлагын газарт өргөдөл, гомдол гаргаж болно.

7.2. Энэхүү журмыг зөрчсөн байгууллага, албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.